

## МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

---

№ 19/2

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг өөрчлөх эсэх талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдаанд макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод тодорхой бус байдлын талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Нийлүүлэлтийн шалтгаантай зарим бүтээгдэхүүний үнийн өсөлт нь инфляцийн багагүй хэсгийг бүрдүүлсэн хэвээр байгаа бөгөөд энэхүү нөлөө 2019 онд буурахааргүй, 2020 онд саарах төлөвтэй байна. Дунд хугацаанд инфляци зорилтот түвшин(8%)-ий орчимд тогтворжих төлөвтэй байна гэж МБГ-аас дүгнэв. Тодруулбал, махны үнэ 5 дугаар сард нийлүүлэлтийн доголдлоос шалтгаалан огцом нэмэгдэж, инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлж байна. Эдийн засгийн идэвхжил, төсвийн зардал болон өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр инфляцийн эрэлтийн хүчин зүйл алгуур нэмэгдэх хандлага хэвээр байна.

Энэ оны эхний улиралд уул уурхайн салбарын олборлолт хүлээлтээс давж, төсвийн төлөв, гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, бизнесийн зээлийн өсөлт тогтворжиж байгаа бол макро зохистой бодлогын нөлөөгөөр хэрэглээний зээлийн өсөлт саарч байгааг зөв чиг хандлага гэж үзэв.

2019 оны эхний улиралд төсвийн орлого өндөр, зарлага дутуу гүйцэтгэлтэй байсан бөгөөд 2019 оны үлдсэн саруудад төсвийн орлого эдийн засгийн идэвхжил, импортын өсөлтөөс үүдэн батлагдсан дүнгээс өсөх төлөвтэй байна. Харин төсвийн зардал батлагдсан төсвийн дагуу бүрэн зарцуулагдаж, барилгын материалын импортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжиж эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт үүсч болзошгүйг анхааруулав.

Хэрэглээний зээлийн өсөлт саарч, бизнесийн зээлийн өсөлт тогтворжиж байна. Банкны системийн нийт зээлийн өсөлт 2019 оны эхнээс саарч, 4 дүгээр сард 19.7 хувьд хүрсэн бөгөөд үүнд хэрэглээний зээлийн жилийн өсөлт 55 хувиас

34 хувь болж буурсан нь голчлон нөлөөлжээ. Мөн бизнесийн чанаргүй зээл өндөр хэвээр байна.

МБГ-ын зүгээс шинээр татсан хадгаламж, олгосон зээлийн хүү 2019 оны эхнээс өссөн болохыг танилцуулж, банкууд эх үүсвэрээ хадгалах зорилгоор том дүнтэй хадгаламжид зарласан хүүнээс өндөр хүү олгож байгаатай холбоотойгоор том дүнтэй хадгаламжийн төлөөх үр ашиггүй өрсөлдөөн өрнөж банкуудын хадгаламжийн хүүний зардал нэмэгдэж, жижиг банкууд өндөр хүүтэй, эрсдэлтэй зээл олгох сэдлийг нэмэгдүүлж байна.

Төлбөрийн тэнцэл 2019 оны эхний улиралд ашигтай гарчээ. Үүнд: 1) үйлчилгээний дансны алдагдал өндөр гарсан ч нүүрс, төмрийн хүдэр, ноолуурын экспортын орлого төсөөллөөс давсан, 2) бүх төрлийн импортын өсөлтийн хурд саарсан, 3) “МИК ОССК” компани гадаад зах зээлд бонд арилжаалж, гадаад зээлийн ашиглалт нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл 2019 онд ашигтай гарч, 2020 онд бага хэмжээний алдагдалтай байхаар байгааг МБГ-ын зүгээс танилцууллаа. Энэхүү төсөөлөлд ӨСХ-ийн хүрээнд донор санхүүжилтүүд үргэлжлэх, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт хуваарийн дагуу хийгдэх нөхцөлийг харгалзан үзжээ. Түүнчлэн Монгол улс гадаад өр төлбөрүүдээ төлж эхлэх хугацаа ойртож байгааг анхаарууллаа.

Гадаад эдийн засгийн төлөв хүлээлтээс муудсан байна. Үүнд Хятадын эдийн засгийн өсөлт 2019 онд 6.2 хувь, Евро бүсийн эдийн засаг хүлээлтээс бага буюу 1.3 хувиар өсөхөөр байгаа нь голлон нөлөөлжээ.

Мөн гадаад орчны хувьд том гүрнүүдийн худалдааны дайн, геополитикийн асуудлууд, АНУ-ын Холбооны нөөцийн банкны шийдвэр зэрэг нь дэлхийн эдийн засгийн өсөлт, түүхий эдийн үнэ, хөгжиж буй орнуудыг чиглэх хөрөнгийн урсгал хэрхэн өөрчлөгдөх тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байгааг онцоллоо. АНУ болон БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн энэ оны 5-р сард ширүүсч, АНУ БНХАУ-аас импортолж буй 200 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүний импортын тарифыг 10 хувиас 25 хувь болгож нэмэгдүүлсэн бөгөөд үүний хариуд БНХАУ 6-р сараас эхлэн 60 тэрбум ам.долларын импортын тарифыг шатлалтайгаар өсгөсөн. Цаашид АНУ нэмэлт 325 тэрбум ам.долларын импортод тариф тогтоож болзошгүй мэдэгдэл хийж байгаа бол БНХАУ ховор үнэт металийн нийлүүлэлтээ зогсоох, БНХАУ-д үйл ажиллагаа явуулж буй АНУ-ын компаниудын гэрээ, хэлцэлд хориг тавих зэрэг чанарын арга хэмжээ авахыг анхааруулж байна. Иймд худалдааны

зөрчилдөөн ширүүсч удаан үргэлжилвэл БНХАУ-ын өсөлт болон түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж, манай эдийн засагт нөлөөлөх болно.

Үүний зэрэгцээ Монгол Улс ФАТФ-ын “саарал жагсаалт”-нд орох тохиолдолд санхүүгийн зуучлалын орчин, гадаад хөрөнгө оруулалт, гадаад худалдааны эргэлт, зээлжих зэрэглэл муудаж, гадаад өрийн хүүний төлбөр нэмэгдэх эрсдэл үүсч болзошгүй.

Түүнчлэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих ажлыг гадаад эх үүсвэрээс санхүүжүүлбэл төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжтой.

Мөнгөний бодлогын газрын зүгээс бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

МБХ-ны гишүүд инфляци дунд хугацаанд зорилтот түвшний орчимд, мөнгөний бодлого эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилттой нийцэж байгаа тул бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалах саналыг дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Хэлэлцүүлгээр дотоод орчны хувьд 2019 оны 1 дүгээр улиралд эдийн засгийн өсөлт нэмэгдсэн нь харьцангуй богино хугацааны шинжтэй буюу Монгол улсын нүүрсний хилийн үнэ дэлхийн зах зээл дээрх үнээс өндрөөр тогтсонтой холбоотой болохыг сануулав. Хэрэв цаашид хилийн үнэ дэлхий зах зээл дээрх үнийг даган буурвал эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Гадаад орчны хувьд худалдааны дайн, сааралт жагсаалт нь тулгамдаад байгаа гол тодорхой бус байдлууд гэдэгтэй санал нэгдсэн бөгөөд одоо байгаа мөнгөний бодлогын төлөвөө хадгалах нь зүйтэй гэж үзсэн юм.

МБХ-ны гишүүд гадаад эдийн засгийн орчинд эрсдэл хуримтлагдаж, ирэх онуудад Монгол Улс гадаад өр төлбөрүүдээ төлж эхлэх тул макро эдийн засгийн бодлогын сахилга батыг хадгалж, дотоод, гадаад тэнцвэрийг хадгалахад чиглүүлэх, өрх, ААН болон улсын секторын түвшинд санхүүгийн нөөцийг хуримтлуулж дунд, урт хугацааны тогтвортой байдалд анхаарал хандуулах шаардлагатай байгаа гэсэн дүгнэлт хийв.

Ийнхүү макро эдийн засгийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв, гадаад дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд Мөнгөний бодлогын хороо энэ удаад бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах саналыг 100% дэмжлээ.

## **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны Мөнгөний Бодлогын Хороо 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.